



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН САЙД

Засгийн газрын III байр, Бага тойруу 44,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14200

Утас: 26 22 27, Факс: (976-51) 26 37 27,

Цахим шуудан: letter@moe.gov.mn,

Цахим хуудас: www.moe.gov.mn

2026.08.24 № 01/4842

танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Ж.ГАЛБАДРАХ ТАНАА

Боловсролын сайдын нэр дээр ирүүлсэн
Таны 2026 оны 8 дугаар сарын 03-ны өдрийн
46 дугаар албан бичигтэй танилцаж, “Боловсролын
шинэчлэлийн талаарх” асуулгын хариуг
хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 10 хуудастай.



1426131082

Боловсролын сайдын 2026 оны
08 дугаар сарын 24-ны өдрийн
01.Ув.дугаар албан бичгийн
хавсралт

“БОЛОВСРОЛЫН ШИНЭЧЛЭЛИЙН ТАЛААРХ”

АСУУЛГЫН ХАРИУ

Асуулга 1. 2026-2027 оны хичээлийн жилээс эхлэн “Сургуулийн хүртээмжийн асуудлыг хотхоны бага сургууль барих, хувийн сургуульд хувьсах зардлын зөрүү олгох замаар шийдвэрлэнэ” хэмээн яамнаас танилцуулсан. Үүнтэй холбоотойгоор сургалтын орчны стандартын асуудал хөндөгдөж байгаа ба хотхоны бага сургуульд стандартыг хэрхэн баримталж, мөрдүүлэх нь тодорхойгүй байна. Түүнчлэн Монгол Улсын засаг захиргааны нэгжид хотхон гэж томъёолол байхгүй тул холбогдох хууль тогтоомжид хэрхэн нийцүүлэх, хотхоны сургуулийн удирдлагын зардал, урсгал зардал, түрээсийн зардал, тэдгээрийн эх үүсвэрийн талаар болон хэдэн сургууль, хэчнээн байршилд байгуулах болон сургуулиудын даац хэтрэлтийг шийдэхэд хэчнээн хувийн сургуультай хамтарч ажиллах, тэдгээрт зарцуулах хувьсах зардлын зөрүүний талаарх тодорхой мэдээлэл

2025-2026 оны хичээлийн жилд өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын 900 сургуульд 824,1 мянган суралцагч суралцсан бөгөөд хамран сургалт бага боловсролд 98.0 хувь, суурь боловсролд 96.4 хувь, бүрэн дунд боловсролд 97.3 хувьтай байна.

Хэдийгээр хамран сургалт өндөр байгаа ч нэн ялангуяа нийслэлд сургуулийн хүчин чадлын ашиглалт хэтэрсэн, бүлэг дүүргэлт нормативаас давсан байдал түгээмэл байна. Улсын хэмжээнд 2025-2026 оны хичээлийн жилд 586,3 мянган суудлын хүчин чадал бүхий 1,374 хичээлийн байрыг ерөнхий боловсролын сургуулиуд ашигласан бөгөөд хүчин чадлаа 2.5 дахин болон түүнээс дээш хэмжээгээр хэтрүүлэн ашигласан 35 сургуулийн 62.9 хувь нь нийслэлд байна. Эдгээр сургуулийн хэтэрсэн ачааллыг бууруулахад 35,4 мянган суудлын хүчин чадал шаардлагатай болох тооцоо гарсан.

Мөн төрийн өмчийн сургуулийн бүлэг дүүргэлтийн улсын дундаж 31.7 байгаа бол 35-аас дээш суралцагчтай 8,538 бүлэг хичээллэсний 71.2 хувь (6,075) нь нийслэлд байна. Статистикийн тооцооллоор 2026-2027 оны хичээлийн жилд суралцагчийн тоо өмнөх хичээлийн жилээс 24,0 мянга орчмоор, 2027-2028 оны хичээлийн жилд өмнөх хичээлийн жилээс дахин 15,0 мянга орчмоор нэмэгдэхээр байна. Гэхдээ энэ өсөлт нь дунд, ахлах ангиудад байх бөгөөд сүүлийн жилүүдэд төрөлт буурсантай холбогдуулан бага ангийн хүүхдийн тоо цаашид буурах төлөвтэй байна.

Энэхүү нөхцөл байдлаас үзвэл сургуулийн хүртээмжийг нэмэгдүүлэх хэрэгцээ байсаар байгаа бөгөөд үүнийг дан ганц улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шийдэх боломжгүй юм. Иймээс Боловсролын яамнаас хүртээмжийг нэмэгдүүлэх хувилбарт арга хэмжээг хэрэгжүүлж байгаагийн нэг нь хотхоны бага сургууль арга хэмжээ юм.

Хотхоны бага сургуулийг дараах чиглэлээр зохион байгуулах ба сургалтын орчны хувьд боловсролын салбарт хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа холбогдох стандарт, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг бүрэн хангуулна. Үүнд:

1. Цэцэрлэгийн хүүхдийн тоо буурч байгаатай холбогдуулан нийслэлийн хотхон, хороололын сул орон зай, анги танхим бүхий цэцэрлэгт 1, 2 дугаар ангийг хичээллүүлэх, ингэхдээ сургалтын хөтөлбөрт нийцүүлэн анги танхим, сургалтын орчинг бэлтгэж, хэрэглэгдэхүүнээр хангах

2. Хувийн хэвшлийн сургуулийн зориулалтаар ашиглах боломжтой орон зайг түрээслэх, ингэхдээ мэргэжлийн байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг дүгнэлт гаргаж, улмаар стандартын шаардлага хангасан тохиолдолд ашиглах зарчим баримтална.

3. Хувийн сургуулийн ашиглаагүй хүчин чадлыг ашиглах.

Иймд Засгийн газраас ерөнхий боловсролын сургуулийн ачааллыг тэнцвэржүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр сургуулийн бүтцийн дахин төлөвлөлт хийх, төрөлжсөн ахлах сургуулийн тогтолцоо (аймаг, дүүрэг бүрд төрөлжсөн ахлах сургууль, бүс бүрд олон улсын хөтөлбөртэй ахлах сургууль байгуулах), сум дундын сургуулийг хөгжүүлэх, хотхон, хороолол болон алслагдсан бүсэд бага сургууль зохион байгуулах, төрийн бус өмчийн сургуулийн сул хүчин чадлыг ашиглах зэрэг арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Эдгээр зохион байгуулалтын хүрээнд нийт 290 анги танхимд 575 бүлгийн 18,960 суралцагчийг хамруулах урьдчилсан тооцоолол хийгдсэн.

Таны асуулгад дурдсан "хотхон" гэсэн нэр томьёо нь Монгол Улсын засаг захиргааны нэгжийн бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөх, эсхүл шинээр засаг захиргааны нэгж бий болгох агуулгыг агуулаагүй болно. Харин хүн амын төвлөрөл, орон сууцны хорооллын суурьшлын онцлог, боловсролын үйлчилгээний эрэлт хэрэгцээнд суурилан төлөвлөлт хийхэд хэрэглэж буй ойлголт юм.

Иймээс хотхон, хороолол болон алслагдсан бүсэд зохион байгуулах бага сургуулиуд нь бие даасан сургууль хэлбэрээр бус, тухайн нутаг дэвсгэрийн харьяалах төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн бүтэц, зохион байгуулалтын хүрээнд үйл ажиллагаа явуулна. Тэдгээрийн удирдлага, хүний нөөц, сургалтын үйл ажиллагаа, урсгал зардлыг харьяа сургуулиар дамжуулан зохион байгуулах бөгөөд санхүүжилтийг салбарын холбогдох хууль тогтоомж, санхүүжилтийн журмын дагуу шийдвэрлэнэ.

Урьдчилсан төлөвлөлтөөр бага сургуулийн үйл ажиллагааг томоохон хотхон, хорооллын хэрэгцээ бүхий 38 байршилд 2026 онд зохион байгуулахаар тооцсон бөгөөд үүнд хүүхдийн тоо буурч, хүчин чадал бүрэн ашиглагдахгүй болсон төрийн өмчийн цэцэрлэгийн 7 барилга, шинээр ашиглалтад орох сургуулийн зориулалттай 6 барилга, сургалтын зориулалтаар ашиглах боломжтой түрээсийн 22 барилга, төрийн бус өмчийн сургуулийн сул хүчин чадлыг ашиглах 3 байршил тус тус хамрагдана.

Түрээсээр ашиглах барилга байгууламжийн зардлыг холбогдох төсвийн хүрээнд санхүүжүүлэх бөгөөд ашиглах барилга байгууламж нь сургалтын орчны стандарт, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг бүрэн хангасан тохиолдолд үйл ажиллагаанд ашиглагдана.

Мөн төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хувийн сургуулийн ашиглагдаагүй хүчин чадлыг ашиглах ажлыг үе шаттай хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд урьдчилсан байдлаар 3 байршилд хамтран ажиллахаар тооцсон. Энэхүү арга хэмжээ нь төрийн өмчийн сургуулийн ачааллыг бууруулж, бүлэг дүүргэлтийг норматив хэмжээнд ойртуулахад чиглэж байна.

Нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэх төрөлжсөн ахлах сургууль болон хотхон, хорооллын бага сургуулийн төлөвлөлтийн үр дүнд 46-аас дээш суралцагчтай 1,089 бүлгээс 971 бүлгийн ачааллыг бууруулах боломж бүрдэх урьдчилсан тооцоо гарсан.

Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэхэд хотхон, хороололд зохион байгуулах бага сургуулийн тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүн болон хувьсах зардалд нийт 36.1 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай бөгөөд уг хэрэгцээг холбогдох төсөв болон дунд хугацааны санхүүгийн төлөвлөлтөд үе шаттайгаар тусган, хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэнэ.

Асуулга 2. Цаашид дунд болон урт хугацаанд сургууль, цэцэрлэгийн анги дүүргэлтийг стандарт хэмжээнд хүргэхэд баримталж буй бодлого, шинээр барихаар төлөвлөж буй сургууль, цэцэрлэгийн байршлын судалгаа болон ашиглалтад орсноор ачаалал хэрхэн буурах талаар хийсэн тооцоо судалгааны талаар мэдээлэл

Цэцэрлэг, сургуулийн хүртээмжийг сайжруулж, бүлэг дүүргэлтийг нормативт хэмжээнд хүргэх зорилгоор хүн амын өсөлт, шилжилт хөдөлгөөн, суурьшлын төлөв байдал, сургуулийн насны хүүхдийн хэтийн төлөв, сургалтын байгууллагын хүчин чадал, ашиглалтын түвшинд үндэслэн богино, дунд, урт хугацаанд баримтлах бодлого, төлөвлөлтийг боловсруулан хэрэгжүүлж байна.

Боловсролын салбарын хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн хүрээнд 2026 онд 25,560 хүүхдийн хүчин чадал бүхий ерөнхий боловсролын 53 сургууль, 2027 онд 45,970 хүүхдийн хүчин чадал бүхий 90 сургууль, 2028 онд 640 хүүхдийн хүчин чадал бүхий 1 сургууль тус тус ашиглалтад орохоор төлөвлөгдсөн байна.

Мөн Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр 2027 оноос 11,140 хүүхдийн хүчин чадал бүхий 33 цэцэрлэг, сургуулийн барилгыг шинээр барихаар төлөвлөсөн бөгөөд Дэлхийн банкны санхүүжилтээр 58,960 суудлын хүчин чадал бүхий ерөнхий боловсролын 70 сургуулийн барилгыг шинээр барьж эхлүүлэх саналыг хүргүүлээд байна.

Шинээр баригдах цэцэрлэг, сургуулийн байршлыг тодорхойлоход хүн амын өсөлтийн хурд, орон сууцны шинэ хороолол, цэцэрлэг, сургуулийн хамран сургах тойргийн хүн амын бүтэц, сургалтын байгууллагын барилга байгууламжийн хүчин чадал ашиглалт, бүлэг дүүргэлт болон ээлжийн коэффициент зэрэг үзүүлэлтэд тулгуурласан хэрэгцээний судалгааг ашиглаж байна. Үүний үр дүнд сургуулийн ачаалал өндөр байгаа нийслэл болон аймгийн төвүүдэд хөрөнгө оруулалтыг түлхүү чиглүүлэх бодлого баримталж байна.

Үүний зэрэгцээ сургуулийн хүртээмжийг зөвхөн шинээр барилга байгууламж барих замаар бус, сургуулийн бүтцийн дахин төлөвлөлтөөр дамжуулан сайжруулах бодлого баримталж байна. Өнөөдрийн байдлаар хүн амын төвлөрөл нийслэл болон зарим аймгийн төвүүдэд өндөр байгаа бол олон суманд сургуулийн хүчин чадал бүрэн ашиглагдахгүй байна. Тухайлбал, ээлжийн коэффициент нэгээс доош үзүүлэлттэй 360 орчим сургууль үйл ажиллагаа явуулж байгаа нь сургалтын орчны нөөцийг илүү оновчтой зохион байгуулах шаардлагатайг харуулж байна.

Мөн ерөнхий боловсролын сургуулийн бүтэц сүүлийн жилүүдэд өөрчлөгдөж, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх сургуулийн эзлэх хувь нэмэгдсэн байна. Тухайлбал, 1989 онд нийт сургуулийн 51 хувь нь суурь боловсролын, 33 хувь нь бүрэн дунд боловсролын бүтэцтэй байсан бол өнөөдөр бүрэн дунд боловсролын сургууль нийт сургуулийн 76 хувийг эзэлж байна. Энэ нь багшийн хүрэлцээ, сургалтын хэрэглэгдэхүүний хангамж, төсвийн үр ашгийн хувьд тодорхой хүндрэл үүсгэж байна.

Иймд дунд болон урт хугацаанд ерөнхий боловсролын сургуулиудын бүтцийг бүсчилсэн хөгжлийн бодлого, хүн амын нутагшилт, хүүхдийн тооны өсөлтийн төлөв, тээвэр, дэд бүтэц, дотуур байрны хүртээмж, багшийн хангамж зэрэг хүчин зүйлийг харгалзан дахин төлөвлөж зохион байгуулах бодлого баримталж байна. Энэ хүрээнд сум дундын бүрэн дунд сургуулийг үе шаттай хөгжүүлэх, аймаг, дүүрэг бүрд төрөлжсөн ахлах сургууль байгуулах, бүс бүрд олон улсын хөтөлбөртэй ахлах сургууль хөгжүүлэх, мөн нийслэлд 3,000-аас дээш суралцагчтай сургуулиудыг өөрчлөн зохион байгуулж ачааллыг тэнцвэржүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Дээр дурдсан хөрөнгө оруулалт болон сургуулийн бүтцийн дахин төлөвлөлтийн үр дүнд сургуулийн суудлын хүчин чадал үе шаттайгаар нэмэгдэж, сургуулийн ачаалал өндөртэй бүс нутаг, ялангуяа нийслэлийн хэмжээнд бүлэг дүүргэлт болон олон ээлжээр хичээллэж байгаа сургуулиудын ачааллыг бууруулах нөхцөл бүрдэнэ. Түүнчлэн шинээр ашиглалтад орох цэцэрлэг, сургуулийн барилга байгууламжийн нөлөөллийг хамран сургах тойрог, суралцагчдын шилжилт хөдөлгөөн, хүчин чадлын ашиглалтын үзүүлэлттэй уялдуулан жил бүр тооцож, цаашид хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд тусган ажиллана.

Асуулга 3. *Боловсролын яамнаас “3000 давсан сурагчтай сургуулийн ачааллыг төрөлжсөн ахлах сургууль байгуулах замаар шийдвэрлэнэ” гэж мэдэгдсэн. “Төрөлжсөн ахлах сургууль” гэдгийг хэрхэн тодорхойлж байгаа ба үүнийг “хөдөлмөрийн зах зээлд шаардлагатай байгаа дунд шатны инженер техникийн ажилтан, үйлчилгээний ажилтан бэлтгэх сургууль, эсхүл сурлага сайтай хүүхдүүдэд зориулсан “ЭЛИТ” сургууль гэх ойлголтын эргэлзээ нийгэмд үүсээд байна. Энэ сургуулийн сургалтын хөтөлбөр нь батлагдсан эсэх, дадлагын хичээл орох сургалтын орчин болон мэргэжлийн хичээл заах багшлах боловсон хүчний нөөцийг хэрхэн хангаж байгаа талаарх дэлгэрэнгүй мэдээлэл*

Төрөлжсөн ахлах сургуулийн зорилго нь суралцагчийн ажил мэргэжлийн сонголтод суурилсан суралцах замналыг дэмжих, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, суралцахуйн ахиц, сайн сайхан байдлыг дээшлүүлэх, ирээдүйд шаардлагатай ур чадварыг хөгжүүлэх, дараагийн түвшний боловсролд үргэлжлүүлэн суралцах болон хөдөлмөрийн зах зээлд шилжих бэлтгэлийг хангахад оршино.

Иймээс төрөлжсөн ахлах сургууль нь зөвхөн сурлагын өндөр амжилттай суралцагчдад зориулсан “элит сургууль” биш, дан ганц мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллагыг орлох хэлбэр ч биш юм. Харин суралцагчийн авьяас, сонирхол, хэрэгцээ, ажил мэргэжлийн сонголт, ирээдүйн суралцах болон хөдөлмөр эрхлэх чиглэлтэй уялдсан сургалтын сонголтыг нэмэгдүүлэх зорилготой ахлах сургуулийн төрөлжсөн загвар болно.

Ахлах сургуулийг төрөлжүүлэн хөгжүүлэхэд баримтлах чиглэлийг Боловсролын сайдын 2026 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн А/246 дугаар тушаалаар баталж, хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна.

Төрөлжсөн ахлах сургууль нь сургалтын хөтөлбөрийн онцлогоос хамааран байгалийн шинжлэх ухаан, математик, инженерчлэл, мэдээллийн технологи, эрүүл мэнд, нийгмийн ухаан, хүмүүнлэг, урлаг, дизайн, спорт зэрэг нэг буюу хэд хэдэн чиглэлээр төрөлжих бөгөөд суралцагчид мэргэжлийн сургалт, политехник коллеж, их сургууль, коллежтой хамтарсан сургалтын хөтөлбөр, олон улсын хөтөлбөрөөс сонгон судлах боломжтой байхаар зохицуулсан.

Сургуулийн төрөлжих чиглэлийг тогтооход тухайн орон нутгийн хөгжлийн онцлог, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, хүний нөөцийн чадавх, сургалтын орчин, дэд бүтцийн нөхцөлийг харгалзсан. Мөн дадлага, туршилт, төсөлд суурилсан

сургалтыг хэрэгжүүлэх зорилгоор их, дээд сургууль, политехник коллеж, шинжлэх ухааны байгууллага, ажил олгогчидтой хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

Төрөлжсөн ахлах сургуулийн багшийн хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах хүрээнд тухайн чиглэлийн мэргэжлийн багш нарыг үе шаттайгаар бэлтгэх, мэргэшүүлэх, давтан сургах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүний зэрэгцээ их сургууль, судалгааны болон мэргэжлийн байгууллагын багш, эрдэмтэн, судлаачдыг сургалтын үйл ажиллагаанд оролцуулах замаар мэргэжлийн хүний нөөцийн чадавхыг бэхжүүлж, сургалтын чанарыг ханган ажиллах юм.

Асуулга 4. Боловсролын салбарын төсвийн хүрээний мэдэгдэл тусгахдаа “Цахим шилжилт хиймэл оюунд хамгийн их хөрөнгө оруулах” зорилго тавьсан байх ба энэ хүрээнд 2027 оны хөгжлийн төлөвлөгөөнд сурагчдын ашиглах цахим төхөөрөмжийг 9:1 харьцааг 5:1 (5 хүүхдийн дунд 1 компьютер) болгохын тулд 640,0 тэрбум, Хромбүүк үйлдвэр байгуулахад 150,0 тэрбум, бусад цахим хэрэглээнд 20,0 тэрбум, нийт 810,0 тэрбум төгрөг төсөвлөхөөр тусгажээ. Цахим хөгжлийн эрин үед хамгийн ихдээ 3-4 ашиглагдах компьютерт их хэмжээний төсөв зарцуулахаар төлөвлөсөн судалгаа, тооцоолол бүхий үндэслэл, үр өгөөжийн талаарх мэдээлэл болон боловсролын чанараар тэргүүлэгч орнууд цахим дижитал шилжилтийг ерөнхий боловсролын сургуульд хэрэгжүүлснээр хийснээр үүсэж буй сөрөг нөлөөллүүдийн талаар дэлхий нийтэд сануулж буйг харгалзсан үзсэн эсэх

Хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан цахим шилжилтийн хөрөнгө оруулалтын зорилго нь суралцагч бүрийн суралцах боломжийг өргөжүүлэх, боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийн ялгааг бууруулах, сургалтын удирдлага болон үнэлгээний тогтолцоог сайжруулахад чиглэж байна.

“Нэг хүүхэд - Нэг компьютер, Нэг анги - Нэг ухаалаг самбар” зорилтот арга хэмжээний хүрээнд суралцагчид байршлаас үл хамааран цахим сургалтын орчин, шилдэг багш нарын бэлтгэсэн сургалтын контент, хиймэл оюун ухаанд суурилсан сургалтын платформ, үнэлгээний хэрэгслийг ашиглах боломжийг бүрдүүлэхээр төлөвлөж байна. Уг арга хэмжээ нь боловсролын чанар, хүртээмжийн ялгааг бууруулахын зэрэгцээ багш нарт суралцагчийн ахиц, хоцрогдлыг бодит өгөгдөлд үндэслэн үнэлэх боломжийг нэмэгдүүлэх зорилготой.

Боловсролын салбарын цахим шилжилтийн суурь нөхцөл болох интернетийн хүртээмж сүүлийн жилүүдэд эрс сайжирсан бөгөөд 2026 оны байдлаар сургуулиудын 98.0 хувь нь олон улсын стандартын шаардлага хангасан хурдтай интернэт сүлжээнд холбогдоод байна. Гэсэн хэдий ч сургалтын зориулалттай компьютер, дижитал төхөөрөмжийн хүрэлцээ хангалтгүй хэвээр байгаа бөгөөд нэг компьютерт дунджаар 11-12 суралцагч ногдож байна. Иймд 2027 он гэхэд энэ үзүүлэлтийг 5 суралцагч тутамд 1 компьютер байх түвшинд хүргэх зорилт тавьж ажиллаж байна.

Төхөөрөмжийн ашиглалтын хугацаа, хөрөнгө оруулалтын үр өгөөжийн тухайд компьютер, дижитал төхөөрөмжийг богино хугацаанд ашиглагдах хэрэглээний хэрэгсэл гэж үзэхгүй бөгөөд боловсролын байгууллагын хөрөнгийн удирдлагын тогтолцооны хүрээнд олон жилийн хугацаанд ашиглах зарчим баримтална. Энэ хүрээнд төхөөрөмжүүдийг нэгдсэн удирдлага, хамгаалалтын системд бүртгэн ашиглалтын хяналт тавих, засвар үйлчилгээний тогтолцоог хөгжүүлэх, ашиглалтын хугацааг уртасгах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Мөн ахлах ангийн суралцагчдын ашигласан төхөөрөмжийг техникийн болон програм хангамж, системийн түвшинд сэргээн шинэчилж (refurbish), бага, дунд ангийн суралцагчид болон сургуулийн мэдээллийн технологийн танхимд

шилжүүлэн ашиглах замаар хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэхээр төлөвлөж байна.

Таны асуулгад дурдсан хромбүүк угсрах үйлдвэрийн тухайд улсын төсвийн хөрөнгөөр үйлдвэр байгуулах асуудал шийдвэрлэгдээгүй бөгөөд боловсролын салбарын төсвийн бодлого нь үйлдвэр байгуулахад бус, суралцагчдад шууд хүрэх сургалтын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэж байна. Иймд уг асуудлыг төр, хувийн хэвшлийн түншлэл болон хөрөнгө оруулалтын боломжит хувилбарын хүрээнд судалж байна.

Олон улсын хэмжээнд боловсролын байгууллагуудад дижитал технологи, хиймэл оюун ухааны хэрэглээг өргөжүүлэхийн зэрэгцээ дэлгэцийн хэрэглээ нэмэгдэх, анхаарал төвлөрөл буурах, унших болон бичих суурь чадварт нөлөөлөх зэрэг эрсдэлийн талаар анхаарч байна. Тухайлбал, Финланд, Швед зэрэг улс бага ангийн түвшинд унших, бичих, тооцоолох суурь чадварыг уламжлалт сургалтын аргаар дэмжихийн зэрэгцээ дижитал технологийн зохистой хэрэглээний бодлогыг хэрэгжүүлж байна.

Монгол Улсын боловсролын салбарын цахим шилжилтийн бодлого нь танхимын сургалтыг цахим сургалтаар орлуулахад бус, харин багшийн сургалт, арга зүйг дэмжих, чанартай сургалтын контентын хүртээмжийг нэмэгдүүлэх, суралцагч бүрийн ялгаатай хэрэгцээнд нийцсэн сургалтыг хэрэгжүүлэхэд чиглэж байна. Иймээс цахим технологийг сургалтын хэрэглэгдэхүүн байдлаар ашиглахын зэрэгцээ хүүхдийн нас, сэтгэл зүйн онцлог, эрүүл мэнд, цахим аюулгүй байдлын шаардлагыг хангах зарчмыг баримтална.

Төлөвлөж буй хөрөнгө оруулалтын үр дүнд нэг компьютерт ногдох суралцагчийн тоо буурч, сургалтын цахим нөөц, хиймэл оюун ухаанд суурилсан сургалтын платформын хүртээмж нэмэгдэхийн зэрэгцээ төв болон алслагдсан бүсийн сургуулиудын сургалтын чанарын ялгааг бууруулах, суралцагчдын мэдлэг, чадварын хоцрогдлыг нөхөх, боловсролын үйлчилгээний хүртээмжийг сайжруулах нөхцөл бүрдэнэ гэж тооцоолж байна.

Асуулга 5. *“Боловсролын сайдын аймаг бүрд Кембрижийн хөтөлбөртэй сургууль байгуулна” гэх мэдэгдэл нь өөрийн орны цөм хөтөлбөрийг чухалчлах бус, гадаад орны хөтөлбөрийг дэмжиж улс орон даяар нэвтрүүлэх, улмаар төр өөрийн санаачилгаар боловсролын ялгаатай байдлыг бий болгосноор үндэсний дархлаа алдагдах, дотоодын эрдэмтэн багш, судлаачдын хөгжих боломж хумигдах эрсдэлийн талаарх үнэлгээ, судалгаа, түүнчлэн Кембрижийн шалгалтын төвд жил бүр Монгол Улсаас төлөх төлбөрийн хэмжээ, улсын төсөвт дэх ачаалал, уг хөтөлбөрийг өмнө хэрэгжүүлэхэд төсөвт учирсан хүндрэлийг хэрхэн давтахгүй байх зэрэг холбогдох асуудлуудыг хэрхэн тооцсон талаарх судалгаа тооцооллын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл*

Засгийн газар хүүхэд бүр хаана амьдарч байгаагаас, нийгэм, эдийн засгийн нөхцөлөөс үл хамааран чанартай боловсрол эзэмших тэгш боломжтой байх зарчмыг боловсролын бодлогын үндсэн чиглэл болгон баримталж байна.

Энэ хүрээнд сургууль бүрийг хүүхдийн бие бялдар, танин мэдэхүй, сэтгэл зүй, нийгэмшихүйн хөгжлийг дэмжсэн сургалтын хөтөлбөртэй, чадварлаг багш, удирдлагатай, хүүхдэд ээлтэй сургалтын орчинтой, ногоон, ухаалаг, эрүүл, аюулгүй боловсролын байгууллага болгон хөгжүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Манай улсын суурь боловсрол эзэмшсэн 15 настай хүүхдүүдийн суралцахуйн үр дүн, ялангуяа уншаад ойлгох чадвар, математик болон байгалийн ухааны суурь чадвар олон улсын дунджаас доогуур түвшинд байгааг олон улсын үнэлгээний

судалгааны үр дүн (ПИСА 2022) харуулсан. Түүнчлэн хот, хөдөө болон сургууль хоорондын боловсролын чанарын ялгаа ч бодитой байна.

Дэлхийн банкны хийсэн судалгаагаар сургалтын орчин, багшийн чанар, сургалтын хэрэглэгдэхүүн, дэд бүтцийн хүртээмж нь суралцахуйн үр дүнд шууд нөлөөлдөг болохыг тогтоосон.

Иймд үндэсний сургалтын хөтөлбөрийн агуулга, чанарыг олон улсын түвшний шаардлагад нийцүүлэх, сургууль хоорондын чанарын ялгааг бууруулах, мөн орон нутагт амьдарч буй суралцагчдад газарзүйн байршлаас үл хамааран олон улсын түвшний боловсрол эзэмших боломжийг хүртээмжтэй хүргэх зорилгоор олон улсын хөтөлбөр хэрэгжүүлэх туршлага бүхий сургуулиудыг бүсчилсэн байдлаар болон нийслэлийн дүүрэг бүрд үе шаттайгаар хөгжүүлэхээр төлөвлөж байна.

Энэхүү бодлого нь Монгол Улсын үндэсний сургалтын хөтөлбөрийг орлуулах эсхүл үндэсний агуулгаас татгалзах зорилго агуулаагүй болно. Харин үндэсний сургалтын хөтөлбөрийг суурь болгон хэрэгжүүлэхийн зэрэгцээ олон улсын сайн туршлага, арга зүй, үнэлгээний тогтолцоо, чанарын шаардлагыг нутагшуулах замаар сургалтын чанарыг сайжруулахад чиглэнэ. Монгол Улсын сургалтын хөтөлбөр, тэр дундаа математик болон байгалийн ухааны хичээлийн агуулга нь Кембрижийн хөтөлбөрийн агуулгатай өндөр түвшний нийцэлтэй бөгөөд үндэсний агуулга, монгол хэл, түүх, соёл, өв уламжлалын сургалтын агуулга бүрэн хадгалагдан хэрэгжинэ. Иймээс энэхүү бодлого нь үндэсний онцлог, үнэт зүйлсийг хадгалах зарчимд тулгуурлан олон улсын жишигт нийцсэн боловсролын чанарыг хөгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ юм.

Түүнчлэн энэхүү бодлогын хүрээнд хөгжүүлэх олон улсын хөтөлбөр хэрэгжүүлэх сургуулиуд нь зөвхөн сурлагын өндөр амжилттай суралцагчдыг сонгон суралцуулах "элит" сургуулийн тогтолцоог бий болгох зорилгогүй бөгөөд боловсролын чанар, тэгш боломжийн хангах хүрээнд орон нутгийн суралцагчдад олон улсын түвшний боловсролыг оршин суугаа газраас үл хамааран хүртээмжтэй хүргэхэд чиглэж байна.

Энэхүү бодлого нь дотоодын эрдэмтэн, судлаач, багш нарын хөгжлийг хязгаарлах бус, харин олон улсын сургалтын арга зүй, үнэлгээний тогтолцоог нутагшуулах, үндэсний сургалтын хөтөлбөрийн чанар, агуулгыг боловсронгуй болгох, багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих шинэ боломжийг бүрдүүлэх ач холбогдолтой. Энэ хүрээнд үндэсний агуулга бүхий сургалтын материал боловсруулах, багш бэлтгэх, хөтөлбөрийн нутагшуулалт хийх ажилд дотоодын их сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, судлаачид идэвхтэй оролцоно.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ өмнөх туршлага, сургамжид тулгуурлан сургалтын чанар, өртөг, үр ашиг, тогтвортой санхүүжилтийн асуудлыг нарийвчлан тооцож, төсвийн үр ашигтай зарцуулалтын зарчимд нийцүүлэн үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Иймээс бүс болон дүүргийн түвшинд олон улсын хөтөлбөр хэрэгжүүлэх сургууль хөгжүүлэх бодлого нь үндэсний сургалтын хөтөлбөрийн чанарыг сайжруулах, олон улсын сайн туршлагыг нутагшуулах, бүс нутаг хоорондын боловсролын ялгааг бууруулах, хүүхэд бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломжийг бүрдүүлэхэд ач холбогдолтой арга хэмжээ юм.

Асуулга 6. *Боловсролын салбарт тулгамдаж байгаа асуудал болох багш бэлтгэхэд нэг ч төгрөг төсөвлөөгүй байгааг хэрхэн ойлгох, багшлах боловсон хүчний тоон болон чанарын хомсдолын талаар их өгөгдөлд суурилсан нарийвчилсан судалгаа, тооцооллыг 2026-2031 оны хичээлийн жил тус бүрээр*

гаргаж, бодлогын ямар баримт бичигт үндэслэн, ямар арга аргачлалаар хийсэн талаарх дэлгэрэнгүй танилцуулга мэдээлэл

Боловсролын салбарын тэргүүлэх зорилтуудын нэг нь багшийн хангалт, чанарыг сайжруулах асуудал байдаг. Ийм учраас Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 192 тогтоолоор “Багшийн 3 тулгуурт бодлого” цогц арга хэмжээг баталж, хэрэгжүүлж байна. Энэхүү бодлого нь багш бэлтгэхээс эхлээд багшийн мэргэжлийн хөгжил, цалин хөлс, нийгмийн баталгаа зэрэг өргөн хүрээний асуудлыг хамарсан бөгөөд эдгээр асуудал нь Монголын багш нарын 8 дугаар их хурлаас гарсан санал, зөвлөмжид үндэслэсэн юм.

Монгол Улсын Засгийн газраас багшийн хангалтыг нэмэгдүүлэх чиглэлээр 2023 оноос багш мэргэжлээр суралцагчдад тэтгэлэг олгож өнөөг хүртэл нийтдээ 8,702 оюутанд 38 тэрбум төгрөгний тэтгэлэг Боловсролын зээлийн сангаас олголоо. 2027 оны улсын төсвийн төсөлд багш мэргэжлээр 15 мянга гаруй суралцагчдад 42 тэрбум төгрөгний тэтгэлэг олгох санхүүжилтийг тусгаад байна.

Багшийн мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагаа, мэргэжил дээшлүүлэх сургалтын зардлыг 2023 оноос эхлэн нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын бүрэлдэхүүнд тусгаж санхүүжилтийг хийж байна. Хувьсах зардлын бүрэлдэхүүн дэх “Багшийн хөгжил”-ийн зардалд жилд (2026 оны байдлаар) дунджаар цэцэрлэгт 2.9 тэрбум төгрөг, ерөнхий боловсролын сургуульд 15.7 тэрбум төгрөгний санхүүжилт олгодог. Тухайлбал, 2026 онд зөвхөн энэ чиглэлээр 18.1 тэрбум төгрөгийн санхүүжилт төсөвлөсөн бөгөөд сургалтын байгууллагууд тухайн эх үүсвэрээр багшийн хөгжлийг дэмжих сургалт, арга зүйн үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж байна. 2027 оны төсвийн төсөлд багшийн хөгжлийн зардалд сургуулийн өмнөх боловсролд 2.6 тэрбум төгрөг, ерөнхий боловсролд 19.1 тэрбум төгрөгний санхүүжилт олгох саналыг хүргүүлсэн.

Таны асуулгад дурдсанчлан багш бэлтгэхэд төсөв тусгагдаагүй гэсэн ойлголт нь бодит нөхцөлтэй нийцэхгүй бөгөөд ерөнхий боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчдад ногдох хувьсах зардлын бүрэлдэхүүнд багшийн мэргэжил дээшлүүлэх, тасралтгүй хөгжлийг дэмжих зардал тусгагддаг.

Багшийн мэргэжлийн хөгжлийн тогтолцоог шинэчлэх хүрээнд 2022 оноос сургуульд суурилсан мэргэжлийн хөгжлийн төв (PDQ Center)-ийн тогтолцоог нэвтрүүлж эхэлсэн. Монгол Улсын Боловсролын их сургуулийн дэргэд Багшийн хөгжлийг дэмжих үндэсний төв ажиллаж байгаа бөгөөд Архангай, Дорнод, Ховд аймагт бүсийн төвүүдийг байгуулан үйл ажиллагааг нь бэхжүүлж байна. Түүнчлэн багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих, мэргэжил дээшлүүлэх харилцааг зохицуулах эрх зүйн орчныг шинэчилж, Кембрижийн сургагч багшийг чадавхжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлсний үр дүнд улсын хэмжээнд 40 мянга орчим багш мэргэжлийн хөгжлийн сургалтад хамрагдаад байна.

Багшийн хүний нөөцийн хэрэгцээ, хангамжийг боловсролын салбарын мэдээллийн нэгдсэн сан, багшийн бүртгэл, суралцагчийн тооны өсөлтийн төсөөлөл, сургуулийн хүчин чадал, орон тоо, багшийн шилжилт хөдөлгөөн, өндөр насны тэтгэвэрт гарах төлөв зэрэг мэдээлэлд үндэслэн тогтмол тооцоолж байна. 2026 оны 6 дугаар сарын статистикийн мэдээллээр улсын хэмжээнд ерөнхий боловсролын сургуулиудад 3,954 багшийн сул орон тоо бүртгэгдсэн байна. Үүний задлан авч үзвэл 632 багш өндөр насны тэтгэвэрт гарсан, 1,590 багш хүүхэд асрах болон бусад шалтгаанаар түр чөлөө авчээ. Нөгөө талаас 2025-2026 оны хичээлийн жилд багш мэргэжлээр бакалаврын зэрэг эзэмшсэн 2,757 төгсөгч хөдөлмөрийн зах зээлд шинээр шилжсэн. Өнгөрсөн оны байдлаар сургуулийн өмнөх боловсролын багшаар төгсөгчдийн 67 хувь нь, ерөнхий боловсролын сургуульд судалдаг судлагдахууны

хөтөлбөрөөр төгсөгчдийн 51 хувь нь мэргэжлээрээ цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд ажиллаж байна.

Эдгээр үзүүлэлтээс харахад багшийн хомсдол нь зөвхөн төгсөгчдийн тооны асуудал бус, бүс нутгийн хүн амын төвлөрөл, багшийн ажлын байрны нөхцөл, нийгмийн баталгаа, алслагдсан орон нутагт ажиллах сонирхол зэрэг олон хүчин зүйлтэй холбоотой байна.

Цаашид багшийн ажлын ачааллыг бууруулах зорилгоор тайлан мэдээ, үнэлгээ, сургалтын төлөвлөлт зэрэг нийтлэг чиг үүргийг үе шаттай цахимжуулах, хиймэл оюунд суурилсан туслах хэрэгслүүдийг нэвтрүүлэх, нэг багшид ногдох суралцагчийн тоог бууруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүний зэрэгцээ багшийн ажлын норм, нормативыг шинэчилж, цалин хөлс, нийгмийн баталгааг үе шаттай сайжруулах замаар ажлын байран дахь тогтвор суурьшлыг нэмэгдүүлэх бодлого баримталж байна.

2026-2027 оны хичээлийн жилээс “Багшийн 3 тулгуурт бодлого” арга хэмжээний хэрэгжилтийг илүү эрчимжүүлж, нарийвчилсан төлөвлөгөөг зардлын хүрээний хамт хийж, холбогдох эрх зүйн актыг шинэчлэх ажлыг эхлүүлээд байна.

Асуулга 7. 2026 оны элсэлтийн ерөнхий шалгалтын дүнгээс харахад бүх хичээлийн анхны гүйцэтгэлийн оноо хангалтгүй түвшинд байгаа нь 18-26 хувьтай буюу маш бага үнэлгээтэй төгсөгч их, дээд сургуульд элсэн орж байгаагаас харагдаж байгаа ба нөгөө талаар боловсролын чанарыг тооцох оноог зөвхөн сурагчдыг эрэмбэлэх хэрэгсэл мэтээр хандаж байгаад дүгнэлт хийж байгаа эсэх, цаашид чанартай боловсролыг хөгжүүлэх талаарх хийхээр төлөвлөж буй өөрчлөлтийн талаарх мэдээлэл

Элсэлтийн шалгалт нь дээд боловсролын сургалтын байгууллагад элсэн суралцах иргэдийн мэдлэг, ур чадварын түвшинг тогтоох зорилготой бөгөөд үнэлгээний даалгавар нь суралцагчдын урьдчилан боловсруулсан блюпринтээр тодорхойлсон, дээд боловсролын сургалтын байгууллагад элсэн суралцахад шаардлагатай мэдлэг, ур чадварын түвшинг тогтоож, эрэмбэлэх зорилгоор боловсруулагддаг. Сүүлийн жилүүдийн элсэлтийн шалгалтын анхны онооны улсын дундаж 2026 он хүртэл тогтмол өсөлттэй байсан бөгөөд 2026 онд бага зэрэг бууралттай байна.

Элсэлтийн шалгалтын үр дүн (2024-2026 он)

№	Хичээл	Шалгуулагчийн тоо			Анхны онооны дундаж		
		2024	2025	2026	2024	2025	2026
1	Түүх	1,385	1,682	1,319	41.2	43.6	36.3
2	Англи хэл	21,475	29,424	31,618	35.7	35.3	38.9
3	Хими	5,930	6,964	6,926	25.3	32.9	29.1
4	Газарзүй	1,030	1,253	1,248	44.1	56.7	46.9
5	Нийгэм судлал	20,010	27,536	30,078	43.7	36.1	39.1
6	Биологи	5,843	6,927	6,811	46.2	34.2	25.7
7	Математик	23,003	31,295	33,097	24.3	20.0	23.5
8	Физик	8,357	10,881	11,663	34.2	35.6	32.0
9	Орос хэл	497	744	479	64.0	64.4	66.9
10	Монгол хэл	11,791	16,679	15,944	38.4	42.9	42.5

Элсэлтийн шалгалтын үр дүн нь шалгуулагч дээд боловсролын сургалтын байгууллагад элсэх суурь нөхцөл болдог учраас шалгуулагчдын эрэмбэлэх зайлшгүй шаардлагатай байдаг. Гэхдээ эрэмбэлэхдээ анхны оноог ашигладаггүй бөгөөд оноог хэмжээсжүүлж стандарт тархалтад шилжүүлэн эрэмбэлдэг. Энэ нь “боловсролын чанарыг тооцох оноо” биш юм.

2023 онд батлагдсан боловсролын багц хуулийн шинэчлэлээр боловсролын чанарыг тогтмол үнэлдэг байх зохицуулалтыг бий болгосон бөгөөд бүх түвшний боловсролын чанарыг үнэлгээг 2022-2023 онуудад хийж үр дүнд үндэслэн бодлогын зөвлөмжийг боловсруулж, бодлого, арга хэмжээнд ашиглаж байна.

Үүнээс гадна суурь боловсролын чанарыг олон улстай харьцуулах, давуу болон сул талыг илрүүлэх зорилгоор Олон улсын эдийн засаг, хөгжлийн хамтын ажиллагааны байгууллагаас 3 жил тутам зохион байгуулдаг “ПИСА” үнэлгээнд манай улс 2 дахь удаагаа хамрагдаад байна. 2022 онд зохион байгуулсан ПИСА үнэлгээний үр дүнгийн тайлан, мэдээллийг олон нийтэд нээлттэй байршуулж, бодлогын зөвлөмжийг гаргаж, хэрэгжүүлж ажилласан. ПИСА 2022 үнэлгээний үр дүн, зөвлөмжид үндэслэн 2024 оны 3 сард Засгийн газрын 105 дугаар тогтоолыг батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Цаашид боловсролын чанарыг сайжруулах, сургуулийн хүртээмжийг нэмэгдүүлэх бодлого, арга хэмжээг тоон болон чанарын өгөгдөл мэдээлэл, нотолгоонд суурилан тасралтгүй сайжруулах бөгөөд энэ чиглэлээр төлөвлөлт хийн ажиллаж байна.

---000---